

2025 оны 01 сарын 28-ны өдөр

№ 2025/08

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.4 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн О.Одбаярын нэгдмэл сонирхолтой этгээд болох хүү О.Одсайханд 19,000,000 /Арван есөн сая/ төгрөгийн хэрэглээний зээлийг дараах нөхцлөөр олгохыг зөвшөөрсүгэй.

Зээлийн хүү	42% /жилийн /
Зээлийн хугацаа	18 сар
Зээл олголтын шимтгэл	1%
Эргэн төлөх нөхцөл	Сар бүр тэнцүү төлөлттэй
Зээлийн зориулалт	Хувийн хэрэгцээнд

2. Зээлийн гэрээ байгуулсантай холбогдуулан зээлийн гэрээний үүргийг хангах баталгаа болгож, О.Одбаяртай батлан даалтын гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулан зээлийн гэрээ болон батлан даалтын гэрээ байгуулах, компанийг төлөөлж холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг (Г.Сүхбаатар)-т олгосугай.

4. Энэхүү санал хураалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ